

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ҮНДСЭН БОЛОН ХҮНДРҮҮЛЭХ ШИНЖ

1. УДИРТГАЛ:

Хүн өөртэйгөө адил бусад хүнээ хүчээр өөрийн дур хүсэл сонирхлын дагуу төрөл бүрийн хэрэгцээндээ өмчийн журмаар хэрэглэж, зарж ажиллуулж, эд бараа мэтээр ашиглах нийгмийн харилцааг боолчлол хэмээн тодорхойлдог. Тэгвэл тус цаг үе улиран одож хүний заяагдмал эрхийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн, ухаалаг, энэрэнгүй, эрх чөлөөт цаг үед бид амьдарч байгаа билээ. Эрхийг эдлүүлэх, хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхэд нийгмийн хамгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх явдал нь өнөөгийн ертөнцийн гол зорилгод тооцогдож байна. Гэсэн хэдий боловч боолчлол нь түүхэнд үлсэн өнгө төрхөө өөрчлөн газар авч хар тамхи, зэвсгийн наймааны нэгэн адил өндөр ашигтай хууль бус нууц орлогын эх сурвалж болж хүний наймаа гэсэн нэршлээр бүлэглэлийн зохион байгуулалт, сүлжээний хэлбэрээр олон улсыг хамарч өргөжин тэлэх болов.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь ихэвчлэн буурай хөгжилтэй болон хөгжиж байгаа орнуудын орлого багатай, боловсролын түвшин доогуур, зорилтот бүлгийн хүүхэд, эмэгтэйчүүд байдаг бөгөөд тухайн орны эдийн засгийн хөгжил доогуур, иргэдийн эрх зүйн мэдлэг муу байгаа зэрэг нь энэхүү гэмт хэргийн хохирогч болох гол хүчин зүйл болж байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр иргэд гадаад улс руу чөлөөтэй зорчиж ажил эрхлэх, аялах боломж бүрдсэн. Нөгөөтгээгүүр гадагшаа гарч ажил, хөдөлмөр эрхэлж орлого олох, амьдралаа дээшлүүлэх гэсэн иргэдийн хүсэл, хэрэгцээ, шаардлага нэмэгдэхийн хэрээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл мөн ихэсдэг байна.

2002 онд баталсан Эрүүгийн хуульд анх удаа хүн хулгайлах, хүн худалдах, худалдан авах, хүний цус, эд эрхтэнг хууль бусаар авах гэмт хэргийг хуульчилсан нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдэх эхлэл тавигдсан. Засгийн газраас 2005 онд “Хүн, ялангуяа эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох, энэ чиглэлээр ажилладаг төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зөв ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зэрэг олон талт үйл ажиллагаанууд хийгдсэн байна.

Манай улсын хувьд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг” конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Палермогийн протоколд */Итали улсын Палермо хотод баталсан учир ийн нэрлэх болсон/* 2008 онд нэгдэн орсон. Ингэснээр УИХ-аас 2012 онд “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” бие даасан хуулийг баталсан билээ.

Хэдийгээр хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн хууль батлагдаж үйл ажиллагааны зарчим, арга хэлбэр, зохион байгуулалт, төрийн байгууллагын бүрэн эрх, хуулийн этгээд, хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг зэргийг тодорхой болгосон ч орчин үеийн нийгэмд шинээр үүсэн бий болсон нөхцөлүүдийн хүрээнд хүндрүүлэх нөхцөлийг дахин тодорхойлох, тогтоох хэрэгцээ үүсээд байна.

Судалгааны арга зүй: Харьцуулсан судалгаа

Эрх зүйн судалгааны ажилд олон улсын практик, гадаад орнуудын хуулийн харьцуулсан судалгаа голлох үүрэгтэй байдаг. Энэхүү судалгааны ажлын хүрээнд олон улсын тэргүүний туршлага болон гадаад орнуудын хууль, эрх зүйн өнөөгийн нөхцөл байдлыг харьцуулсан судалгаа хийж, Монгол Улсад нийцэхүйц боломжит хувилбарыг сонгон дэвшүүлэх ажиллагааг гүйцэтгэв. Юун түрүүнд хамгийн тохиромжтой гэж үзсэн гадаад улсыг олон улсын тайлан, судалгааны дүнг үндэслэн сонгож, тухайн орнуудын практик, хууль тогтоомж, хэрэгжилтийг тодорхой хэдэн шалгуураар сонгон судалдаг ба өөрийн хуулийн төсөлд тусгах гол санаа, бичвэрүүдийг орчуулга хийж Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлтэй харьцуулав.

Судалгааны зорилт:

Судалгааны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулж баримт бичгийн анализ хийх, судлах;
2. Монгол Улсын Эрүүгийн хуулийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх нөхцөлийг тогтоох;
3. Харьцуулан судлах гадны улс орнуудыг тогтоож тус улсуудын хуулийг судлах;
4. Дээрх мэдээллүүдийг нэгтгэн дүгнэлт боловсруулах.

2. ҮНДСЭН ХЭСЭГ

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүний эрхийг ноцтойгоор зөрчдөг бөгөөд өөрөө маш нарийн ээдрээт хэрэгт тооцогддог. Уялдаа холбоо харилцан шүтэлцээтэй арга барилаар ажиллах хэрэгцээ шаардлагад үндэслэн олон улсын байгууллагууд болон улс орны Засгийн газрууд, цагдаа хүчний байгууллагууд, төрийн бус байгууллагуудын дэмжлэг, хамтын ажиллагааны үндсэн дээр тус гэмт хэрэгтэй тэмцэх олон төрлийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг. Учир нь тус гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нэг төрөл юм. Иймд тус гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд нэн тэргүүнд хууль тогтоогчид болон энэ талаар үүрэг хүлээсэн төрийн албан хаагчид, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж буй шүүгчид уг үзэгдлийн мөн чанарын талаар нэгдсэн арга зүй, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь чухал.

Манай улсад болон олон улсад дараах байдлаар хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлсон байна. Үүнд:

- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Палермогийн протоколд:

“Хүн худалдаалах гэмт хэрэг” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах үйлдлийг ойлгоно¹.

- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3.1.1.-т

¹ IRIM судалгааны хүрээлэн, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, Монгол Улс, Улаанбаатар хот, 2022 он

"хүн худалдаалах" гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг²;

- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлгийн 13.1 дүгээр зүйлд:

1. Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ³.

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-г

Хүн худалдаалах гэмт хэрэг хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахууль өгөх зэрэг аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулан хүлээн авсан хууль бус үйлдлээр илэрдэг⁴. ...зэргээр тус тус тодорхойлжээ.

Манай улсын хувьд дээрх байдлаар хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлохдоо Палермогийн протоколтой агуулгын хувьд нийцүүлсэн ба зарим төрлийн үйл ажиллагааг илүү дэлгэрүүлсэн зүйлс мөн ажиглагдаж байна. Гэвч Монгол Улсын Эрүүгийн хуулийн дараах заалтуудад хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, хэлбэрүүдийг харьцангуй бага ялтайгаар давхар зүйлчилсэн байна. Үүнд:

- 12.3 Бэлгийн мөлжлөг,
- 13.13 Албадан хөдөлмөрлүүлэх,
- 15.3 Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах,
- 16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах
- 16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах
- 16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах
- 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх зэрэг ХХГХ-ийн төрөл хэлбэрүүдийг бие даасан байдлаар хуульчилжээ.

Хүндрүүлэх нөхцөлийн хувьд дараах тохиолдлыг тодорхойлсон байна. Үүнд:

хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

² Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль /2012/-ийн 3 дугаар зүйл 3.1.1 дэх заалт

³ Эрүүгийн хууль /2015/-ийн 13 дугаар зүйлийн 1

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Мөн тус гэмт хэргийг байнга тогтвортой; зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ гэж заасан байна.

Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг ашиг олох зорилгоор бага насны болон 14-18 насанд хүрээгүй хүнийг албадан оруулж үйлдсэн тохиолдолд зүйлчлэлийг хүндрүүлэн ял оногдуулахаар заасан. Гэтэл тус хуулийн 13.1-д хүүхдийн эсрэг ХХГХ-ийг үйлдсэн тохиолдолд ямар арга хэлбэрээр үйлдэгдсэн байгааг үл харгалзан шийдвэрлэхээр заасан байна. Өөрөөр хэлбэл ямар нэг ашиг олох зорилгоор хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлсэн тохиолдолд тус хоёр заалтын алийг нь шийдвэрлэх эсэх нь тодорхойгүй байна⁵.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар олон улсын хууль, эрх зүйн баримтлал

Сингапур:

Зүүн өмнөд Ази нь хүн худалдаалах гэмт хэргийн (TIP) голомт гэдгээрээ алдартай. НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээлснээр Зүүн Өмнөд Азиас жил бүр 150,000 гаруй хүн худалдаалагддаг гэсэн судалгаа бий.

Тус улс Хүний наймааны эсрэг хууль (Prevention of Human Trafficking Act, ПНТА) – 2014 онд баталсан байна. Энэхүү хуулиар хүний наймааны гэмт хэргийг тодорхойлж, гэмт хэрэг үйлдэгчдэд хариуцлага тооцох, хохирогчдыг хамгаалах, гэмт хэргийн илрүүлэлт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорьсон. Хуулийн дагуу хүний наймааны гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдэд дараах ял шийтгэл ногдуулдаг:

Нэгдүгээр удаагийн зөрчил: 10 хүртэлх жилийн хорих ял, 100,000 Сингапур доллар хүртэлх торгууль, 6 хүртэлх удаагийн саваадах /нарийн хулсан саваа, мод/ шийтгэл.

Дахин энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд: 15 хүртэлх жилийн хорих ял, 150,000 Сингапур доллар хүртэлх торгууль, 9 саваадах /нарийн хулсан саваа, мод/ шийтгэл.

Энэхүү хуулиар дараах үйлдлүүдийг хүн худалдаалах гэмт хэрэг гэж үзэхээр хуульчилсан байна. Үүнд:

- Хүнийг хүчээр, айлган сүрдүүлгээр, хуурмаг мэдээлэл өгч, хүч хэрэглэж, авлига өгч эсвэл авсан байдлаар урьж, тээвэрлэж, шилжүүлж, нууж, хүлээн авах.
- Хүүхдийг дээрх аргуудаар урьж, тээвэрлэж, шилжүүлж, нууж, хүлээн авах.
- Хүнийг хүний наймааны гэмт хэрэг үйлдсэн гэдгийг мэдэж байсан ч төлбөр авсан этгээдүүдийг гэмт хэрэгт тооцно.

Түүнчлэн, хүний наймааны гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийг дараах нөхцөл байдлаар илүү хүнд гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл ногдуулдаг. Үүнд:

- Хохирогч нь хүүхэд (18 нас хүртэл) байсан.
- Хохирогч нь бие махбодын эсвэл сэтгэл санааны хувьд эмзэг буюу эмгэг, гэмтэлтэй
- Гэмт хэрэг үйлдэгч нь төрийн албан хаагч байсан.
- Гэмт хэрэг үйлдэгч нь хохирогчийн итгэл найдвар, эрх мэдлийг ашигласан.
- Гэмт хэрэг нь хохирогчийг амь насанд нь аюул учруулсан.
- Гэмт хэрэг үйлдэхдээ нь зэвсэг эсвэл мансууруулах бодис ашигласан.

⁵ IRIM судалгааны хүрээлэн, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, Монгол Улс, Улаанбаатар хот, 2022 он.

Эдгээр нөхцөл байдлууд нь гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл болж ял шийтгэл нь нэмэгддэг байна.

Мөн Сингапурт хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн бусад хууль тогтоомжууд ч хэрэгжиж байна:

1. Эмэгтэйчүүдийн хуулийн тухай хууль (Women's Charter): Энэхүү хуулиар биеэ үнэлэх, биеэ үнэлэгчдийг хамгаалах, биеэ үнэлэх үйл ажиллагааг зохицуулах, хохирогчдыг хамгаалах зэрэг асуудлуудыг зохицуулдаг.
2. Гадаад ажилчдын хуулийн тухай хууль (Employment of Foreign Manpower Act): Гадаад ажилчдыг ажиллуулах, тэдний эрхийг хамгаалах, хууль бус хөдөлмөр эрхлэлтийг таслан зогсоох зэрэг асуудлуудыг зохицуулдаг.
3. Гадаад ажилчдын агентлагийн хуулийн тухай хууль (Employment Agencies Act): Гадаад ажилчдын зуучлалын үйл ажиллагааг зохицуулах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зэрэг асуудлуудыг зохицуулдаг.

Эдгээр хуулиуд нь хүний наймааны гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчдыг хамгаалах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлээр чухал үүрэг гүйцэтгэдэг.

Сингапур улс нь хүний наймааны эсрэг хатуу хууль эрх зүйн тогтолцоотой бөгөөд 15 граммаас дээш героин, 500 граммаас дээс каннабис буюу мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, алан хядах ажиллагаа буюу терроризм, санаатай хүн амины хэрэг, галт зэвсэг ашиглан үйлдсэн хүнд гэмт хэрэг зэргээс гадна онц хүнд нөхцөл байдал тогтоогдсон зарим төрлийн хүн худалдаалах гэмт хэрэгт цаазын ял оноодог байна. Энэ мэт хатуу хариуцлага тооцдог нь хүний эрхийг хамгаалах, гэмт хэргийн илрүүлэлт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Сингапур нь манай улсаас ялгаатай нь хүний наймааны хохирогчдыг албадан хөдөлмөрлүүлдэг, заримдаа дамжин өнгөрөх улс болдог. Тус улс нь хүний наймааны золиос болсон хүмүүс зорчиж, эсвэл эцсийн хүрэх газар, тухайлбал зорьсон улс руу шилжихээсээ өмнө түр хугацаагаар оршин суудаг бүс болоод буй юм.

Оросын Холбоон Улс

ОХУ-ын Эрүүгийн хууль 1996 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан ба сүүлд 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1. 127.1 дүгээр зүйл “Хүний наймаа”

Энэхүү зүйл заалтаар хүний наймааны гэмт хэргийг тодорхойлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага тооцох үндэслэлүүдийг зааж өгдөг. Хуулиар хүний наймааны гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийг дараах үйлдлүүдэд оролцсон гэж үздэг: Үүнд:

- Хүнийг худалдах, худалдан авах, түүнтэй холбоотой хэлэлцэл, түүнчлэн түүнийг мөлжих зорилгоор хийсэн хэлцэл/хүлээн авах, тээвэрлэх, шилжүүлэх, нуун дарагдуулах, хүлээн авах зэрэг. Дээрх тохиолдолд 5 жил хүртэлх хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлэх, эсвэл 6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Дээрх үйлдлийг 2 ба түүнээс дээш этгээд бүлэглэн үйлдсэн, насанд хүрээгүй хүнийг худалдаалсан, албан тушаалын байдлаа ашигласан, ОХУ-ын хилээр нэвтрүүлсэн, гаргасан, хуурамч бичиг баримт ашигласан, түүнчлэн хохирогчийн биений байцаалт гэрчлэх баримт бичгийг хураан авч нуун дарагдуулсан, устгасан, хүчирхийлсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эс, эд, эрхтэнг худалдаалах зорилготой байсан, хохирогч жирэмсэн байсан зэрэг тохиолдолд

тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 15 хүртэлх жилээр хасах, 3-10 жил хорих ял шийтгэнэ. Хүндрүүлэх нөхцөл тогтоогдсон бол 8-15 жилээр хорих ял шийтгэнэ.

Мөн дээрх гэмт хэргийг анх удаа үйлдсэн, хохирогчийг сайн дураар чөлөөлсөн, хэргийг илрүүлэхэд хамтран ажилласан этгээдийн үйл ажиллагаанд гэмт хэргийн бүрэлдэхүүн илрээгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжтой.

Ял шийтгэл: Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн дагуу хүний наймааны гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдэд хорих ял, бүх насаар хорих ял, торгууль, хөрөнгө хураах зэрэг ял шийтгэлүүдийг ногдуулдаг:

Торгууль: Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгууль ногдуулах боломжтой.

Хөрөнгө хураалт: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хөрөнгийг хураах шийтгэл ногдуулах боломжтой.

Хорих ял: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг 5-аас 15 жил хүртэлх хугацаагаар хорих ял оноож болно.

Бүх насаар нь хорих ял: Онц хүнд нөхцөл байдалтай хүний наймааны гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдэд бүх насаар нь хорих ял оноож болно.

127 дугаар зүйлд хүн худалдаалах гэмт хэрэгт тав хүртэл жил хорих ял оноох; хүндрүүлэх нөхцөл байдал нь 15 жил хүртэл хорих ялыг сунгаж болно гэсэн заалттай ба тус хуулийн 152-р зүйлд насанд хүрээгүй хүүхдийг худалдаж авсан, худалдсан тохиолдолд 5 жил хүртэл хорих ял шийтгэнэ гэж заасан байдаг. Ихэнхдээ хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг 240, 241-р зүйлд заасны дагуу биеэ үнэлэлт, биеэ үнэлэлт зохион байгуулсантай холбоотой гэсэн үндэслэлээр буруутгадаг тул эдгээр гэмт хэргийг шүүхээр нотлоход хялбар байдаг

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хуулийн нэр: Crime Law of the People's Republic of China

Үндсэн ялын хэмжээ: Хүн худалдаалах гэмт хэрэгт ял оноохдоо 10 хүртэл жил хорих ял оноодог. Тогтоосон ялын хэмжээ гэмт хэргийн хэлбэр, нөхцөл байдлаас хамаарна.

Хятадын Эрүүгийн хуульд хүний наймааны гэмт хэрэгт оногдуулах ялын хүндрүүлэх нөхцөлүүдийг тодорхой заагаагүй ч, 240-р зүйлд дурдсан нөхцөлүүдийг үндэслэн ял шийтгэл тогтоодог. Үүнд гэмт бүлгийн удирдагч байх, 3 ба түүнээс дээш хүнийг худалдах, хүний бие махбодод хүч хэрэглэж, хүчирхийлэл үйлдэх, хүнийг биеийн эрхтэн шилжүүлэх зорилгоор худалдах, хүнийг гадаад улс руу худалдах, хохирогчид ноцтой гэмтэл учруулах зэрэг нөхцөл байдал тогтоогдвол цаазаар авах ял хүртэл оноодог байна.

Хөнгөрүүлэх нөхцөл: Гэмт хэрэгт оролцогч нь албадлагад автсан эсвэл өөрийгөө хохирогчийг зарим талаар хамгаалалтад байлгасан, тусламж үзүүлсэн зэргээ нотолсон тохиолдолд хөнгөрүүлсэн ял шийтгэл онооно.

Япон

Япон улс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжийн хүрээнд идэвхтэй ажилладаг. Япон дахь хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг хууль эрх зүйн зохицуулалт нь хэд хэдэн хуулиудад тусгагдсан байдаг бөгөөд тэдгээр нь эрүүгийн хууль, хөдөлмөрийн хууль, цагаачлалын хууль, хүүхдийн хамгааллын хууль зэрэгт багтдаг.

1. Эрүүгийн хууль (刑法 – "Keihō")

Японы эрүүгийн хууль нь хүн худалдаалах гэмт хэргийг шууд болон шууд бусаар зохицуулдаг.

Гол заалтууд:

Эрүүгийн хууль 224-р зүйл “Хүн хулгайлах”, 225-р зүйл “Хууль бусаар хүнийг хөдөөлүүлэх буюу тээвэрлэх”, 226-р зүйл “Хүнийг гадаадад хууль бусаар тээвэрлэх”, 227-р зүйл “Эдгээр гэмт хэргүүдийн турхиралт, хамсаатны хариуцлага”

Ял шийтгэл:

Дээрх хэмт хэргүүдэд 5 жилээс 20 жил хүртэл хугацаагаар хорих ял оноодог ба хэрэв гэмт хэрэг нь хүчирхийлэл, заналхийлэл, албадлага зэрэгтэй хосолсон бол илүү хүндрүүлсэн ял оноодог.

2. Арбайт буюу хөдөлмөрийн хууль (労働基準法 – "Rōdō Kijun Hō")

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг албадан хөдөлмөр эрхлүүлэх нь Японы хөдөлмөрийн хуулийг зөрчиж байгаа хэрэг болдог.

Хууль зөрчсөн тохиолдолд: Аж ахуйн нэгж, хувь хүн хариуцлага хүлээж, торгууль, аж ахуйн үйл ажиллагаа зогсоох, хорих ял авч болно.

3. Цагаачлалын хууль (入管法 – Nyūkanhō)

Гадаадын иргэдийг хууль бусаар оруулж ирэх, барьцаалах, паспортыг нь хураах зэрэг үйлдлүүд нь хүний наймааны нэг хэлбэрт тооцогддог.

Хариуцлага: Хууль бусаар хүн оруулсан бол 5 жил хүртэл хорих, эсвэл үйл ажиллагааг хасах, хязгаарлах, депорт хийх.

4. Хүүхдийн эрхийн тухай хууль ба Хүүхдийн бэлгийн мөлжлөг (児童買春・児童ポルノ禁止法)

Гол заалтууд:

- 18 нас хүрээгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах – 5-10 жилийн хорих ял.
- Хүүхдийн порнографи үйлдвэрлэх, эзэмших, дамжуулах – 1-5 жил хүртэл ял онооно.

Хохирогчдын хамгаалалт

Япон улсын Цагдаагийн газар болон Хууль зүйн яам нь хүний наймааны хохирогчдыг түр хамгаалах байр, орчуулгын үйлчилгээ, хууль зүйн туслалцаа үзүүлдэг байна. Мөн гадаадын иргэдийн хувьд хүчээр ажиллуулсан эсэх, барьцаалагдсан нөхцөл, хүчирхийлэлд өртсөн зэрэг нь нотлогдвол оршин суух тусгай зөвшөөрөл (жишээ нь "зохих хамгаалалтын оршин суух") олгох боломжтой.

ДҮГНЭЛТ

Хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай, хүний эрхийг ноцтой зөрчдөг гэмт хэрэг бөгөөд дэлхий нийтээр нэгдмэл, хүчтэй хариу арга хэмжээ авах шаардлагатай асуудлын нэг хэвээр байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн эмэгтэйчүүд, хүүхдүүдийг чиглэсэн, нарийн зохион байгуулалттай, далд сүлжээтэй, өндөр орлого бүхий, олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг гэмт бүлэглэлүүдтэй холбоотой байна.

Монгол Улсын хувьд эрх зүйн орчин нь Палермогийн протокол болон олон улсын гэрээ, хэм хэмжээнд нийцүүлэн, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн суурь орчинг бүрдүүлсэн боловч:

- Эрүүгийн хуульд энэхүү гэмт хэрэгтэй холбоотой төрөл хэлбэрүүдийг салангид, давхардсан байдлаар зүйлчилсэн.
- Хүүхэдтэй холбоотой хүн худалдаалах үйлдлийг ялгаж зүйлчлэх болон өөр хоорондоо зөрчилдөх, давхардсан заалтуудтай.
- Урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тогтолцоо тогтмол, тогтвортой биш...

...зэрэг сайжруулах, дутагдалтай талууд ажиглагдаж байна.

Сингапур, ОХУ, БНХАУ, Япон зэрэг орнуудын туршлагаас харахад:

- Хүн худалдаалах гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэл нь тодорхой заагдсан, бодитой, сэргийлэмжтэй байна.
- Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, түр хамгаалах байр, хууль зүйн тусламж, оршин суух зөвшөөрөл олгох зэрэг бодлого хэрэгждэг.
- Албан тушаалтан, төрийн албан хаагчид гэмт хэрэгт оролцсон бол илүү хатуу шийтгэл ногдуулдаг.
- Эрүүгийн хууль, хөдөлмөр, хүүхдийн эрх, цагаачлалын зэрэг салбар хуулиуд уялдаа холбоотойгоор хэрэгждэг...

... зэрэг давуу талууд ажиглагдаж байна.

Санал, зөвлөмж

- ✓ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, хэлбэрүүдийг нэгтгэж, ял оногдуулах үндэслэл, хүндрүүлэх нөхцөлийг тодорхой болгох. Тухайлбал, хүүхэдтэй холбоотой бүх төрлийн хүн худалдаалах үйлдлийг 13.1 дүгээр зүйлд нэгтгэн хүндрүүлэх нөхцөл тусгах;
- ✓ Бусад давхар зүйлчилсэн заалтууд (12.3, 13.13, 15.3, 16.4, 16.6 гэх мэт)-ыг уялдуулан нэгтгэж, ялгамжтай, тодорхой болгох.
- ✓ Хүндрүүлэх нөхцөлүүдийг илүү нарийвчлан хуульчлах. Үүнд:
 - Хохирогч нь хүүхэд, жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн байсан;
 - Гэмт хэрэг төрийн албан хаагчийн оролцоотойгоор үйлдэгдсэн;
 - Албадан хөдөлмөр, эрхтэн авах, олон удаа давтан үйлдсэн;
- ✓ Хохирогчийг хамгаалах тусгай хууль тогтоомж, тогтолцоог сайжруулах шаардлагатай. Үүнд:
 - Түр хамгаалах байр, нөхөн сэргээх төвийг тогтмол санхүүжилттэй байлгах;
 - Сэтгэл зүйч, хуульч, орчуулагч бүхий мэргэшсэн хамтарсан баг ажиллуулах;
 - Урьдчилан сэргийлэх ажлыг идэвхжүүлж, олон нийт, эрсдэлт бүлгийн иргэдэд чиглэсэн эрх зүйн сургалт, мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулалттай явуулах.
 - Сургуулийн насны хүүхдүүд, алслагдсан хөдөө орон нутгийн иргэд, гадаадад ажиллах сонирхолтой хүмүүсийг онцгойлон хамруулах.
 - Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээг ашиглан нөлөөллийн ажил явуулах.
- ✓ Гадаадын туршлага, олон улсын стандартыг нутагшуулах зорилгоор:
 - Харьцуулан судалсан улсуудын ялын бодлогоос хорих болон торгох, хөрөнгө хураах, албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хориглох, сэргийлэмжийн ач холбогдлыг анхаарах;
 - Төрийн албан хаагч, эрх бүхий албан тушаалтан энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд авах ял шийтгэлийг тодорхой заах;
 - Японы хүүхэд хамгааллын хууль, ОХУ-ын бүлэглэлийн эсрэг ял шийтгэлийн бодлогыг судалж, нэвтрүүлэх;

Ашигласан эх сурвалжууд:

- Авилагтай тэмцэх газар, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Урангар Пресс ХХК, Улаанбаатар хот, 2022 он.
- Хууль зүй дотоод хэргийн яам, “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: албан хаагчдыг чадавхжуулах нь” гарын авлага, Би Си Ай ХХК, Улаанбаатар хот 2018 он.
- IRIM судалгааны хүрээлэн, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2022 он.
- Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт “ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”

Цахим эх сурвалжууд:

- <https://sso.agc.gov.sg/Act/PHTA2014?ProvIds=P12-#pr4->
- https://www-consultant-ru.translate.google.com/document/cons_doc_LAW_341379/?x_tr_sl=ru&x_tr_tl=mn&x_tr_hl=en&x_tr_pto=wapp#dst100029
- https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/4a5e2bbfdd061dde65a55bb65d36d4b4a7fe8ee7/
- <https://legalinfo.mn/mn/detail/554>